

БИЗНЕСИЙН БАЙГУУЛЛАГА ДАХЬ ИННОВАЦИЙН ТӨРӨЛ БА ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ НӨЛӨӨЛӨЛД ХИЙСЭН СУДАЛГАА

Н.Сонинтамир*, Н.Оюунжаргал*,
Н.Батдэлгэр*, Д.Батхуяг**

Хураангуй: Инновацийн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, амжилттай хэрэгжүүлэх үндэс нь инновацийн хэрэгжилтийн явц байдал, түвшинд үнэлгээ хийх, нөхцөл байдлыг зөв тодорхойлох явдал билээ. Инновацийн үйл ажиллагаа бизнесийн байгууллагад хэрхэн явагдаж буйг үнэлэх зорилгоор UNESCO Institute for Statistics (UIS) хоёр жил тутамд инновацийн судалгаа явуулдаг. Хамгийн сүүлчийн 2017 оны глобал инновацийн мэдээлэл цуглуулалтанд Монголын бизнесийн 300 байгууллага хамрагдсан. Монгол улсын БСШУСЯ нь UNESCO-ийн дэмжлэгээр инновацийн асуулга явуулах судалгааны байгууллагыг сонгон шалгаруулж, хамтран ажилласан бөгөөд, судалгааны тоон мэдээллийг инновацийн чиглэлээр судалгаа хийдэг эрдэмтэн судлаачид ашиглах боломжийг хангаж байна. Монголын бизнесийн аж ахуйн нэгж, байгууллагын инновацийн үйл ажиллагааг тодруулах 2017 оны судалгааны тоон мэдээлэлд үндэслэн ААНБ-уудын хэрэгжүүлж буй инновацийн үйл ажиллагааны төрөл чиглэлүүд болон тэдгээрт ямар төрлийн хууль тогтоомжууд хамааралтай байгааг тодорхойлох зорилгоор энэхүү өгүүллийг бичиж бэлтгэлээ.

Түлхүүр үгс: Инновацийн төрөл, Монголын бизнесийн байгууллагуудын инновацийн үйл ажиллагаа, Инновацид хууль эрх зүйн зохицуулалтын нөлөө.

Abstract: The evaluation of the innovation implementation process and the determination of the current status is the foundation for the further innovation program development and its successful implementation. UNESCO conducts innovation surveys carried out every two years, in order to evaluate innovation activity in enterprises. In 2017, Mongolia contributed first time to the global innovation survey by collecting innovation activity data from 300 enterprises. The initiative was a result of a collaboration between Mongolian Ministry of Education, Science, Culture and Sports and UNESCO. The Ministry coordinated the survey and selected a research organization to conduct the survey. The collected data was made available for scientists interested in the innovation research field. In this paper, based on data from the Innovation Survey 2017 to study innovation activity in Mongolian enterprises, we aim to discuss the innovation types and trends of the enterprises, and determine influence of legal regulation on the innovation activities.

Keywords: Innovation Types, Innovation Activities in Mongolian business entities, Influence of legal regulation on the innovation.

* МУИС-ийн Бизнесийн сургууль, (Email) nsonintamir@num.edu.mn

** МУИС-ийн Бизнесийн сургууль, докторант

ОРШИЛ

Үндэслэл: Инноваци нь нийгэм-эдийн засгийн хөгжлийг шийдвэрлэх гол хүчин зүйл болон дэлхий дахинаа хүлээн зөвшөөрөгдөөд байгаа сүүлийн гуч гаруй жилийн хугацаанд инноваци, үндэсний инновацийн тогтолцоо, тогтолцооны гол субьектүүдийн гүйцэтгэх чиг үүргийн талаар олон эрдэмтэд судлаачид байр сууриа илэрхийлэн өөрсдийн үзэл хандлага, загваруудыг хөгжүүлсээр ирлээ. Энэхүү сэтгэлгээний хөгжилтэй зэрэгцэн улс үндэстнүүд инновацийг бодит амьдралд хэрэгжүүлэхэд хүчин чармайлт гаргаж, тэргүүний сайн туршлагуудыг ч, амжилт ахицаар бага кейсүүдийг ч толилуулсаар байна.

Инновацийн үзэл баримтлалын хөгжлийн болон хэрэгжүүлэлтийн туршлагын үр дүнд инноваци нь урьд өмнө огт байгаагүй, абсолют утгаараа цоо шинэ зүйл биш, харин тухайн нөхцөл байдалд оршин байгаа асуудлыг шийдэх шинэ гарц олох, ингэснээр шинэ үйл ажиллагаа явуулах боломжийг олгох үйл явц гэдэгт судлаачдын дийлэнх нэгэнт нэгджээ [3], [5], [6], [7], [13], [14], [15]. Чухам энэ нэгдлийн үр дүнд инновацийг шаардлагатай түвшингүүдээр авч үзэх, түвшин бүр оролцогчдын хэрэгцээнд суурилсан прагматик инновацийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь чухлыг улам ихээр мэдрэх болсон.

Инновацийг нэвтрүүлж, амжилттай хэрэгжүүлэхийн тулд инновацийн одоогийн явц байдал, түвшинг үнэлэх шаардлага зүй ёсоор тавигдана. Олон улсын түвшинд инновацийн судалгааг хийх арга зүйг боловсронгуй болгох, инновацийн мэдээлэл цуглуулах, харьцуулалт хийх, үзүүлэлт үр дүнг нэгдмэл байдлаар ойлгох, тайлбарлан таниулахтай холбоотой ажлын хэрэгцээ шаардлага 1980-1990-ээд онуудад хүчтэй бий болж, энэ чиглэлээр ихээхэн хүчин чармайлт гаргасан байдаг. Үүний үр дүнд 2004 оноос “Networked Readiness Index”³, 2007 оноос “Global Innovation Index”⁴, 2008 оноос “Knowledge Economy Index”⁵, 2012 оноос UIS Innovation Rates-ийг улс орнуудаар тооцдог болоод байна.

Инновацийн цогц үйл явц дахь сүүлийн үе шатуудад, өөрөөр хэлбэл, бусдын болон өөрийн бий болгосон шинэ мэдлэгийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх (технологийг хэрэглэх), зах зээлд гаргах (үр дүнг ашиглах) үе шатуудад инноваци хэрхэн явагдаж байгааг үнэлэхэд илүүтэй ач холбогдол өгсөн судалгааны арга зүй [11] ашиглан UIS нь 2010 оноос эхлэн инновацийн хэмжүүрийг тодорхойлох, үнэлэх үйл ажиллагааг эхлүүлж, түүнээс хойш нэг туршилтын, хоёр удаагийн глобал мэдээллийг 2013, 2015 онуудад цуглуулж, 2015 болон 2017 онуудад үр дүнгээ дэлхийд зарлаад байгаа билээ. UIS-

³ Economic Forum-аас гаргадаг. Тус индексийн одоогийн нэршил нь Global Information Technology Report by World Economic Forum

⁴ World Intellectual Property Office, INSEAD, Cornell University хамтран гаргадаг.

⁵ The World Bank Institute-ээс гаргадаг.

ийн 2017 оны мэдээлэл цуглуулалтанд Монгол орон хамрагдсанаар 2019 оны илтгэлд тодорхой үзүүлэлтүүдээр олон улсын түвшинд харьцуулагдах боломж нэмэгдэгдэж байна. Мөн Монголын бизнесийн байгууллага дахь инновацийн үйл ажиллагаа хэрхэн явагдаж байгааг үнэлэхэд чиглэгдсэн мэдээллийн сан бүрдэж, хоёр жил тутамд баяжиж байх юм. Энэхүү тоон мэдээллийг бид БСШУЯ-нд хүсэлтээ гарган авч ашиглаж байна.

Судалгааны зорилго, судлах зүйл. Монголын бизнесийн аж ахуйн нэгж, байгууллагын инновацийн үйл ажиллагааг тодруулах 2017 оны судалгааны тоон мэдээлэлд үндэслэн 300 ААНБ-ын хувьд хэрэгжүүлж буй инновацийн төрөл, хэлбэрүүд, тэдгээрийн хэрэгжилтэнд хууль эрх зүйн орчны үзүүлэх нөлөөллийг тодруулан судлана. Үүний тулд, өгүүллийн **нэгдүгээр** хэсэгт инновацийн төрөл хэлбэрүүдийг, **хоёрдугаар** хэсэгт ААНБ-ууд дахь инновацийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг, **гуравдугаар** хэсэгт инновацийн хэрэгжилтэнд хууль эрх зүйн орчны үзүүлэх нөлөөллийг судалж, дүгнэлээ. Инновацийн төрлүүдээс логистикын болон үйл явцын инновацийг Монголын ААНБ-ууд харьцангуй бага хэрэгжүүлдэг, бүтээгдэхүүний аюулгүй байдалтай холбогдох хууль тогтоомжууд нь бүтээгдэхүүн үйлчилгээний инновацид хамгийн их нөлөөтэй гэж таамагласан.

Судалгааны арга зүй: Инновацийн төрлүүдийг тодруулахдаа энэ чиглэлээр судалгаа хийсэн эрдэмтдийн бүтээлийг суурь болгон ашиглаж, нэгтгэв. ААНБ-уудын инновацийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг инновацийн төрөл тус бүрээр дискриптив анализ хийж тодорхойлсон бол салбар тус бүрийн хэрэгжилтийн байдлыг кросстаб анализ хийж тодорхойлсон. Харин ААНБ-уудын хэрэгжүүлж буй инновацийн төрөл ба хууль тогтоомжуудын статистик ач холбогдолын түвшин дэх хамаарлыг дискриптив анализ болон Хи квадрат (Chi-square) шалгуур хамаарлын шинжилгээ хийж тодорхойллоо.

НЭГ: ИННОВАЦИЙН ТӨРӨЛ

Аливаа шинжлэх ухаан хөгжлийнхөө явцад шинэ ойлголт ухагдахууныг дэвшүүлж, нэгэнт дэвшүүлсэн ойлголтоо тал талаас нь тодорхойлж, шинэчилж, эсвэл түүний олон төрөл хэлбэрүүдийг дэвшүүлж байдаг. Инновацийн олон төрлүүдийг судалаачид тодорхойлсон. Аливаа ойлголтын төрлийг судлахдаа тухайн төрлийг бий болгохдоо юуг шалгуур болгож авч вэ гэдэг нь чухал байдаг.

Байгууллага дахь инновацийн төрлүүдийг тухайн төрөл ангилалыг бий болгоход эрдэмтдийн баримталсан шалгуур үзүүлэлтэд нь үндэслэн тоймлон гаргаж үзвэл, инновацийн эрчмээр нь тасралтгүй сайжруулах (incremental) инноваци, радикал (radical) инноваци [9], инновацийн эх үүсвэрээр нь R&D and non-R&D инноваци гэж ангилна. Өөрөөр хэлбэл инноваци болсон шинэ

мэдлэгийг байгууллага өөрийн судалгаа хөгжүүлэлтийн үр дүнд бий болгосон эсэх талаас нь ангилж байна. Инновацийн объектоор нь бүтээгдэхүүний инноваци, процессийн инноваци, маркетингийн инноваци, зохион байгуулалтын инноваци [11] гэсэн төрлүүдэд хуваана. Мөн энэ шалгуураар инновацийг 10 төрөлд хуваасан судлаач ч байна [10]. Иновацийг хэрэгжүүлэх стратеги талаас нь нээлтэй ба хаалтай [12] гэж, инновацийн менежмент хийх чиглэл талаас дээрээс доош, доороос дээш чиглэсэн инноваци [9] гэж байна.

Инновацийн дээрх төрлүүдийг бий болгосон шалгууруудын хослол дээр төрөл хэлбэрүүд бий болж байна. Жишээ нь сүйтгэгч (disruptive) инноваци нь радикал бөгөөд судалгаа хөгжүүлэлтийн нэн чухал нээлтэй холбоотой инноваци [12], [2], [8] юм.

Мөн инновацийг тухайн орон нутгийн болон байгууллагын хэрэгцээ шаардлага, нөхцөл байдалд нийцсэн бодлого хөтөлбөрөөр хөгжүүлэх хандлага буюу прагматик инновацийн хүрээнд: арвич (frugal) инноваци [7], пирамидын суурь (Bottom of the Pyramid-BOP) инноваци [4], сошал (social) инноваци, хүртээмжтэй (inclusive) инноваци [1], [5], [13] гэх ойлголтууд маш хүчтэй түгж байна.

Бид энэхүү өгүүлэлд инновацийг объект талаас нь ангилсан ангилал болох дараах төрлүүдийг Монголын бизнесийн байгууллагууд хэрхэн хэрэгжүүлж байгааг авч үзсэн. Үүнд: 1/ Бүтээгдэхүүний инноваци гэдэг нь шинж чанар, хэрэглээ зориулалтын утгаараа шинэ эсвэл мэдэгдэхүйц сайжирсан байраа бүтээгдэхүүн, эсвэл үйлчилгээ нэвтрүүлэхийг хэлнэ. 2/ Үйл явцын инноваци гэдэг нь шинэ эсвэл мэдэгдэхүйц сайжруулсан үйлдвэрлэл, ханган нийлүүлэх арга ажиллагаа хэрэгжүүлснийг хэлнэ. Үүнд: арга техник, тоног төхөөрөмж, эсвэл програм хангамж багтана. 3/ Зохион байгуулалтын инноваци гэдэг нь компанийн бизнесийн үйл ажиллагаа, ажлын байрны зохион байгуулалт, эсвэл гадаад харилцаанд авч хэрэгжүүлсэн бүтэц, зохион байгуулалтын шинэ арга хэмжээг хэлнэ. 4/ Маркетингийн инноваци гэдэг нь маркетингийн шинэ арга ажиллагаа хэрэгжүүлэхийг хэлэх бөгөөд үүнд бүтээгдэхүүний загвар эсвэл сав баглаа боодол, бүтээгдэхүүний байршуулалт, сурталчилгаа, үнэд оруулсан мэдэгдэхүйц өөрчлөлтийг ойлгоно.

ХОЁР: БИЗНЕСИЙН БАЙГУУЛЛАГА ДАХЬ ИННОВАЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ААНБ-уудын инновацийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг дискриптив анализ хийж тодорхойлов. Үүнд салбарын ангилал, инновацийн төрөл тус бүрээр хэрэгжилтийн байдал, салбар тус бүрээр инновацийн хэрэгжилтийн харьцуулалт зэргийг авч үзсэн .

Хүснэгт 1. Салбарын ангилал

№	Салбарын ангилал	Frequency	Valid Percent
1	Барилга	30	10.0
2	Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбарын үйл ажиллагаа	30	10.0
3	Боловсруулах үйлдвэр	30	10.0
4	Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйл ажиллагаа	30	10.0
5	Зочид буудал, зоогийн газар	30	10.0
6	Нийгэм, бие хүнд үзүүлэх үйл ажиллагаа	30	10.0
7	Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	30	10.0
8	Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	30	10.0
9	Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа	30	10.0
10	Хөдөө аж ахуй, уул уурхай, олборлох үйлдвэр	30	10.0
Total		300	100.0

Судалгаанд нийт 300 ААНБ хамрагдсан бөгөөд үйл ажиллагаа явуулж буй салбарын ангилалаар авч үзэхэд хөдөө аж ахуй уул уурхайн олборлох үйлдвэр, банк санхүү, зочид буудал зоогийн газар, боловсрол эрүүл мэнд нийгмийн халамж, тээвэр агуулахын аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, нийгэм бие хүнд үзүүлэх үйл ажиллагаа, барилга угсралт, үл хөдлөх хөрөнгө түрээсийн үйл ажиллагаа, бөөний болон жижиглэнгийн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйл ажиллагааны чиглэл гэсэн 10 салбар тус бүрээс 30 ААНБ хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан ААНБ-уудын инновацийн хэрэгжилтийн байдлыг бүтээгдэхүүн үйлчилгээний инноваци, үйл явцын инноваци, бүтэц зохион байгуулалтын инноваци, маркетингийн инноваци, логистикийн инноваци гэсэн 5 төрөлд авч үзэхэд дараахь үр дүн гарч байна

Бүтээгдэхүүн үйлчилгээний инновацийн хүрээнд хэрэгжүүлсэн долоон төрлийн үйл ажиллагаанаас “бүтээгдэхүүний материал эд ангийг сольж үйл ажиллагаа чанарыг сайжруулсан” үйл ажиллагаа хамгийн их буюу 65.3%, “үйлчилгээний салбарт мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан” үйл ажиллагаа 63.3%, “бүтээгдэхүүний чанарт мэдэгдэхүйц өөрчлөлт шинэчлэлт гарсан” үйл ажиллагаа 61.0% тус тус байна. Хэрэгжүүлж буй нийт үйл ажиллагааны дундаж утга 59 %- тай байна.

Хүснэгт 4. Бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээний үйл явцын инноваци


№	Хариулт	Үйлдвэрлэлийн шаг процессд шинэ эсвэл дэвшилтэд арга нэвтрүүлсэн	Ханган нийлүүлэлтийн түвшинд шинэ эсвэл дэвшилтэд арга нэвтрүүлсэн	Бүтээгдэхүүний агуулах, тээвэрлэх, үйлчилгээ үзүүлэх зэрэг түгээлгийн шатанд шинэ эсвэл дэвшилтэд аргыг нэвтрүүлсэн	Худалдан авалтын үйл ажиллагаа, няглан бодох бүртгэл, тооцоолол хийх зэрэг байгууллагыг дэмжих үйл явцуудад шинэ эсвэл дэвшилтэд арга нэвтрүүлсэн	Үйлчилгээний явцад шинэ дэвшилтэд арга нэвтрүүлсэн
1	Тийм	41.7	36.7	35.0	42.3	46.3
2	Үгүй	58.3	63.3	65.0	57.7	53.7
Total		100.0	100.0	100.0	100.0	100.0

Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээний үйл явцын инновацийн хүрээнд хэрэгжүүлсэн таван төрлийн үйл ажиллагаанаас “үйлчилгээний явцад шинэ дэвшилтэд арга нэвтрүүлсэн” үйл ажиллагаа хамгийн өндөр буюу 46.3% хэрэгжиж байна. Хэрэгжүүлж буй нийт үйл ажиллагааны дундаж утга 40.4% тай байна.




Бүтэц зохион байгуулалтын хүрээнд хэрэгжүүлж буй долоон төрлийн үйл ажиллагаанаас 50 – иас дээш хувьтай хэрэгжиж байгаа дөрвөн үйл ажиллагаа байна. Үүнд “ажлын байрны сэтгэл ханамжийг нэмэгдүүлсэн” үйл ажиллагаа хамгийн өндөр буюу 69.3%, “компаний бүтэц зохион байгуулалтад бүрэн эсвэл хэсэгчилсэн шинэчлэлт хийсэн” үйл ажиллагаа 64.0%, “компаний дүрэм журамд бүтэн эсвэл хэсэгчилсэн шинэчлэлт хийсэн” үйл ажиллагаа 61.7% , хүний нөөцийн үйл ажиллагаанд дэвшилтэд арга барил нэвтрүүлсэн “ үйл ажиллагаа 57.-% тай тус тус байна. Хэрэгжиж буй нийт үйл ажиллагаануудын дундаж утга 55% байна.

Логистикын инновацийн хүрээнд хэрэгжиж буй долоон төрлийн үйл ажиллагааны нийт дундаж утга нь 24%-тай байгаа нь энэ төрлийн инновацийг судалгаанд хамрагдсан байгууллагууд цөөн хэрэгжүүлж байгааг харуулж байна. Дээрх үйл ажиллагаануудаас “онлайн ханган нийлүүлэлтийн үе шатанд дэвшилтэд арга технологи нэвтрүүлсэн” үйл ажиллагаа хамгийн өндөр буюу 30.7%-тай хэрэгжиж байна.



Нийт 300 ААНБ-аас бүтээгдэхүүн үйлчилгээний инновацийг 257, үйл явцын инновацийн 219, маркетингийн инновацийг 238, бүтэц зохион байгуулалтын инновацийг 235, логистикын инновацийг 168 байгууллага тус тус хэрэгжүүлсэн байна. Дийлэнх ААНБ-ууд бүтэц зохион байгуулалтын болон бүтээгдэхүүн үйлчилгээний инноваци, үйл явцын болон маркетингийн инновацийг хэрэгжүүлж байгаа бол логистикын инновацийг харьцангуй цөөхөн байгууллага хэрэгжүүлж байна.



ААНБ – уудын инновацийн хэрэгжилтийн байдлыг салбар тус бүрээр авч үзэхэд бүтэц зохион байгуулалтын инноваци, бүтээгдэхүүн үйлчилгээний инноваци, маркетингийн инновацийг бүх салбарын байгууллагууд ижил түвшинд хэрэгжүүлж байна. Логистикын инновацийг бусад инновацийн төрлүүдтэй харьцуулахад хэрэгжүүлж буй байгууллагуудын тоо зарим салбарт харьцангуй бага байна.

ГУРАВ. ИННОВАЦИЙН ХЭРЭГЖИЛТЭНД ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Инновацийн үйл ажиллагааны хэрэгжилтийн байдалд хууль эрх зүйн орчин хэрхэн нөлөөлж байгааг дискриптив анализ болон Хи-квадрат (Chi-square) шалгуур хамаарлын шинжилгээ хийж тодорхойлов. Хуулийн хүрээнд бүтээгдэхүүний аюулгүй байдалтай холбогдох хууль тогтоомжууд, хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдох хууль тогтоомжууд, үйл ажиллагааны болон ажилчдын аюулгүй байдалтай холбогдох хууль тогтоомжууд, оюуны өмчтэй холбогдох хууль тогтоомжууд, ажил эрхлэлт, нийгмийн хамгаалалтай холбогдох хууль тогтоомжууд, татварын болон бусад хууль тогтоомжуудыг авч үзсэн.

Хүснэгт 7. Инновацийн үйл ажиллагаан дахь хууль тогтоомжийн нөлөөлөл

		Бүтээгдэхүүний аюулгүй байдалтай холбогдох хууль, тогтоомжууд	Хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдох хууль, тогтоомжууд	Үйл ажиллагааны болон ажилчдын аюулгүй байдалтай холбогдох хууль, тогтоомжууд	Оюуны өмчтэй холбогдох хууль, тогтоомжууд	Татварын хууль	Ажил эрхлэлт, нийгмийн хамгаалалтай холбогдох хууль, тогтоомжууд	Бусад хууль тогтоомжууд
1	Эерэг нөлөө үзүүлсэн	19.7	27.3	32.3	21.3	15.0	18.7	7.0
2	Сөрөг нөлөө үзүүлсэн*	22	25,3	25,4	18,4	52,4	37,7	40,7
3	Нөлөө үзүүлээгүй	58.3	47.3	42.3	60.3	32.7	43.7	52.3
Total		100	100	100	100	100	100	100

* Сөрөг нөлөө үзүүлсэн гэдэгт бэрхшээл учруулсан, тодорхой бус байдал үүсгэсэн, дарамт бий болгосон, тэгш үйлчилдэггүй гэсэн утгуудыг нэгтгэн авч

үзсэн.

ААНБ-уудын инновацийн үйл ажиллагаанд хууль тогтоомж тус бүр хэрхэн нөлөөлж байгааг авч үзэхэд дараахь үр дүн гарч байна. Үүнд бүтээгдэхүүний аюулгүй байдалтай холбогдох хууль тогтоомжийн хувьд байгууллагуудын 41.7% нь нөлөөлсөн гэж хариулсан бөгөөд үүнээс 19.7 % нь эерэг, 22 % нь сөрөг нөлөө үзүүлсэн гэж үзсэн байна. Хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдох хууль тогтоомжуудын хувьд 52.6% нь нөлөө үзүүлсэн гэж хариулсан бөгөөд үүнээс 27.3% нь эерэг, 25.3% нь сөрөг нөлөөлсөн гэж хариулсан байна. Үйл ажиллагааны болон ажилчдын аюулгүй байдалтай холбогдох хууль тогтоомжуудын хувьд байгууллагуудын 57.7% нь нөлөө үзүүлсэн гэж хариулсан бөгөөд үүнээс 32.3% буюу дийлэнх нь эерэг, 25.4% нь сөрөг нөлөө үзүүлсэн хэмээн хариулжээ. Оюуны өмчтэй холбогдох хууль тогтоомжуудын хувьд 39.7% нь нөлөө үзүүлсэн гэж хариулсан бөгөөд үүнээс 21.3% нь эерэг нөлөө, 18,4% нь сөрөг нөлөө үзүүлсэн гэжээ. Татварын хуулийн хувьд авч үзэхэд 67.4% хувь нь нөлөө үзүүлсэн гэж хариулсан бөгөөд үүнээс дийлэнх буюу 52.4% нь сөрөг, 15.0% нь эерэг нөлөө үзүүлсэн хэмжээн хариулсан байна. Ажил эрхлэлт, нийгмийн хамгаалалтай холбогдох хууль тогтоомжуудын хувьд байгууллагуудын 56.4% нь нөлөө үзүүлсэн, үүнээс дийлэнх буюу 37.7% нь сөрөг, 18.7% нь эерэг нөлөө үзүүлсэн гэж хариулсан байна. Бусад хууль тогтоомжуудын хувьд бол 47.7% нь нөлөө үзүүлсэн, үүнээс дийлэнх буюу 40.7% нь сөрөг, 7% нь эерэг нөлөө үзүүлсэн гэж үзсэн байна.

Инновацийн үйл ажиллагааны чиглэл тус бүрээр хууль тогтоомжуудын хамаарлыг авч үзэхэд дараахь үр дүн гарч байна.

Хүснэгт 8. Хи-квадрат шалгуур хамаарлын шинжилгээний үр дүн


№	Хууль тогтоомжууд	Инновацийн төрөл	Хи ² -ын утга*	P-ийн утга**
	Бүтээгдэхүүний аюулгүй байдалтай холбогдох	Технологи өөрчлөх замаар шинэ хэрэглээ бий болгосон	22.608	0.000
		Ханган нийлүүлэлтийн түвшинд шинэ эсвэл дэвшилтэд арга нэвтрүүлсэн	26,627	0.000
		Худалдан авалтын үйл ажиллагаа нягтлан бодох бүртгэл, тооцоолол хийх зэрэг байгууллагыг дэмжих үйл явцуудад шинэ эсвэл дэвшилтэд аргуудыг нэвтрүүлсэн	29,198	0.000
	Бүтээгдэхүүний аюулгүй байдалтай холбогдох	Бүтээгдэхүүн үйлчилгээний үний бодлогод шинэ эсвэл дэвшилтэд бодлого стратеги нэвтрүүлсэн	29.502	0.000

Хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбоотой	Үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд өөрчлөлт хийж чанарыг сайжруулсан	22,423	0.000
	Худалдан авалтын үйл ажиллагаа нягтлан бодох бүртгэл, тооцоолол хийх зэрэг байгууллагыг дэмжих үйл явцуудад шинэ эсвэл дэвшилтэд аргуудыг нэвтрүүлсэн	26,278	0.000
	Маркетингийн бодлого үзэл баримтлалд шинэ дэвшилтэд арга технологи нэвтрүүлсэн	22,933	0.000
	Бүтээгдэхүүн үйлчилгээний үний бодлогод шинэ эсвэл дэвшилтэд бодлого стратеги нэвтрүүлсэн	32,556	0.000
	Бүтээгдэхүүн үйлчилгээний урамшуулалын шинэ арга хэрэгсэл, систем нэвтрүүлсэн	30,033	0.000
Үйл ажиллагааны болон ажиллагчдын аюулгүй байдалтай холбогдох	Технологи өөрчлөх замаар шинэ хэрэглээ бий болгосон	23,166	0.000
	Худалдан авалтын үйл ажиллагаа нягтлан бодох бүртгэл, тооцоолол хийх зэрэг байгууллагыг дэмжих үйл явцуудад шинэ эсвэл дэвшилтэд аргуудыг нэвтрүүлсэн	26,278	0.000
Татварын хууль	Үйлчилгээний үйл явц ад шинэ эсвэл дэвшилтэд арга нэвтрүүлсэн	26,496	0.000
	Бүтээгдэхүүн үйлчилгээний үний бодлогод шинэ эсвэл дэвшилтэд бодлого стратеги нэвтрүүлсэн	24,233	0.000
Ажил эрхлэлт нийгмийн хамгаалалтай холбогдох	Худалдан авалтын үйл ажиллагаа нягтлан бодох бүртгэл, тооцоолол хийх зэрэг байгууллагыг дэмжих үйл явцуудад шинэ эсвэл дэвшилтэд аргуудыг нэвтрүүлсэн	26,022	0.000
	Ажлын байрны сэтгэл ханамжийг нэмэгдүүлсэн	22,876	0.000
	Компаний дүрэм журамд хэсэгчлэн эсвэл бүрэн дүүрэн шинэчлэлт хийсэн	24,620	0.000
Бусад	Худалдан авалтын үйл ажиллагаа нягтлан бодох бүртгэл, тооцоолол хийх зэрэг байгууллагыг дэмжих үйл явцуудад шинэ эсвэл дэвшилтэд аргуудыг нэвтрүүлсэн	23,416	0.000
	Бүтээгдэхүүн үйлчилгээний үний бодлогод шинэ эсвэл дэвшилтэд бодлого стратеги нэвтрүүлсэн	22,639	0.000

* Чөлөөтийн зэрэг 5 үеийн Хи квадратын утга.

** Хамаарал бий эсэхийг илтгэх Р-ийн утга нь дээрх 18 харьцуулалтын хувьд 0.000 байгаа нь бүх хос хувьсагчдийн хооронд ач холбогдлын түвшинд хамаарал байгааг харуулж байна.

Зураг 4. Хи-квадрат судалгааны үр дүнгийн нэгтгэл



* Хаалтанд байгаа тоо нь тухайн төрлийн хууль тогтоомж нь хэдэн инновацийн үйл ажиллагааны чиглэлтэй хамрааралтай байгааг илэрхийлнэ.

Дүгнэлт

ААНБ-уудын инновацийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, түүнд хууль эрх зүйн орчны үзүүлэх нөлөөлөлийг авч үзэн дараахь дүгнэлтийг хийж байна. Инновацийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг 10 салбарын 300 байгууллага дээр инновацийн 5 төрлийн 32 үйл ажиллагааны хүрээнд авч үзэхэд хэрэгжилтийн түвшин 48%-тай байна. ААНБ-уудын инновацийн хэрэгжилтийн байдлыг салбар тус бүрээр авч үзэхэд бүтэц зохион байгуулалтын инноваци, бүтээгдэхүүн үйлчилгээний инноваци, маркетингийн инновацийг бүх салбарын байгууллагууд ижил түвшинд хэрэгжүүлж байна. Харин логистикын инновацийг бусад инновацийн төрлүүдтэй харьцуулахад хэрэгжүүлж буй байгууллагуудын тоо цөөн байна.

Инновацийн үйл ажиллагааны хэрэгжилтэнд хууль эрх зүйн орчин хэрхэн нөлөөлж байгааг 7 хуулийн хүрээнд авч үзэхэд хамгийн өндөр тоогоор эерэг нөлөө үзүүлсэн хууль нь үйл ажиллагааны болон ажилчдын аюулгүй байдалтай холбогдох хууль тогтоомжууд байгаа бол татварын хууль хамгийн өндөр тоогоор сөрөг нөлөө үзүүлж байна. Мөн ажил эрхлэлт, нийгмийн хамгаалалтай холбогдох хууль тогтоомжууд болон бусад хууль тогтоомжууд сөрөг нөлөө үзүүлсэн гэсэн хариултын тоо олон байна. Харин бүтээгдэхүүний аюулгүй байдалтай холбогдох, хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдох, мөн оюуны өмчтэй холбогдох хууль тогтоомжууд эерэг болон сөрөг нөлөө үзүүлсэн гэж хариулсан тооны үзүүлэлт ойролцоо түвшинд байна.

Инновацийн үйл ажиллагааны хэрэгжилт тус бүрээр хууль тогтоомжуудын хамаарлыг авч үзэхэд дараахь үр дүн гарч байна. Бүтээгдэхүүн үйлчилгээний инновацийн хүрээнд хэрэгжиж буй долоон төрлийн үйл ажиллагаануудаас гурав нь бүтээгдэхүүний аюулгүй байдалтай холбогдох хууль тогтоомж, хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдох хууль тогтоомж, үйл ажиллагаа болон ажиллагчдын аюулгүй байдалтай холбогдох хууль тогтоомжуудтай хмааралтай байна. Үйл явцын инновацийн хүрээнд хэрэгжиж буй таван төрлийн үйл ажиллагаанаас гурав нь бүтээгдэхүүний аюулгүй байдалтай холбоотой хууль тогтоомж, хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, үйл ажиллагааны болон ажиллагчдын аюулгүй байдалтай холбогдох хууль тогтоомж, ажил эрхлэлт нийгмийн хамгаалалтай холбогдох хууль тогтоомж, татварын хууль, бусад хууль тогтоомжуудтай хамааралтай байна. Бүтэц зохион байгуулалтын инновацийн хүрээнд хэрэгжиж буй долоон төрлийн үйл ажиллагаанаас хоёр нь ажил эрхлэлт нийгмийн хамгаалалтай холбоотой хууль тогтоомжуудтай хамааралтай байна. Маркетингийн инновацийн хүрээнд хэрэгжиж буй зургаан төрлийн үйл ажиллагаанаас дөрөв нь бүтээгдэхүүний аюулгүй байдалтай холбогдох хууль тогтоомж, хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай

холбогдох хууль тогтоомж, татварын хууль, оюуны өмчтэй холбогдох хууль, бусад хууль тогтоомжуудтай хамааралтай байна. Логистикын инновацийн хүрээнд хэрэгжиж буй үйл ажиллагаануудад хамааралтай хууль тогтоомжууд шинжилгээгээр гарсангүй.

Энэхүү судалгааны ажлын хязгаарлагдмал тал нь инновацийн үйл ажиллагааны төрөл тус бүр ямар хууль тогтоомжтой статистик ач холбогдлын түвшинд хамаарал байгааг тодорхойлсонд байгаа бөгөөд цаашид инновацийн үйл ажиллагаанд хууль, тогтоомжууд хэрхэн яаж нөлөөлж байна вэ гэсэн дараа дараагийн судалгааны ажлыг хийх шаардлагатай гэж судлаачдын зүгээс үзэж байна.

Ашигласан материал

- [1] Chataway, J., Hanlin, R., & Kaplinsky, R. Inclusive innovation: an architecture for policy development. *Innovation and Development*, 4 (1), 2014. 33–54.
- [2] Christensen, C. M., Raynor, M., & McDonald, R. What Is Disruptive Innovation? *Harvard Business Review*, 93(12), 2015. 44–53.
- [3] Foster, C., & Heeks, R. Conceptualising Inclusive Innovation: Modifying Systems of Innovation Frameworks to Understand Diffusion of New Technology to Low-Income Consumers. *The European Journal of Development Research*, 25(3), 2013. 333–355.
- [4] Kolk, A., Rivera-Santos, M., & Rufin, C. Reviewing a Decade of Research on the “Base/Bottom of the Pyramid” (BOP) Concept. *Business & Society*, 53(3), 2014. 338–377.
- [5] Levidow, L., & Papaioannou, T. Which inclusive innovation? Competing normative assumptions around social justice. *Innovation and Development*, 2017. 1–18.
- [6] Lundvall, B.-A., Chaminade, C., Vang, J., & Joseph, K. (Eds.). *Handbook of Innovation Systems and Developing Countries: Building Domestic Capabilities in a Global Setting*. Edward Elgar Publishing. 2009.
- [7] Pansera, M. Frugality, Grassroots and Inclusiveness: New Challenges for Mainstream Innovation Theories. *African Journal of Science, Technology, Innovation and Development*, 5(6), 2013. 469–478
- [8] Satell, G. The 4 Types of Innovation the Problems They Solve. *Harvard Business Review*. 2017.
- [9] Gaynor, G. *Innovation by Design: What It Takes to Keep Your Company on the Cutting Edge (First)*. New York, NY, USA: Amacom. 2002.

- [10] Keeley, L., Walters, H., Pikkell, R., & Quinn, B. *Ten Types of Innovation: The Discipline of Building Breakthroughs*. Wiley. 2013.
- [11] OECD. (2005). *Oslo Manual: Guidelines for Collecting and Interpreting Innovation Data* (3rd ed.).
- [12] Stefik, M., & Stefik, B. *Breakthrough: Stories and Strategies of Radical Innovation*. MIT Press: 2004.
- [13] The World Bank. *Innovation Policy: A guide for Developing Countries*. Washington DC: The World Bank. 2010.
- [14] Tilman Altenburg. *Building Inclusive Innovation Systems in Developing Countries: Challenges for IS Research*. Edward Elgar Publishing. 2009.
- [15] UNCTAD. *Innovation policy tools for inclusive development*. Geneva: United Nations Conference on Trade and Development. 2014.